МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

“УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХИ ТӨСӨӨЛӨЛ 2011” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2012 ОН.

Агуулга

Агуулга 2
Хүснэгтийн жагсаалт 2
I. Судалгааны арга зүй 4
I.1. Судалгааны үндэслэл, зорилго 4
I.2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй 4
I.3. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ 5
II. Судалгааны үр дүн 6
II.1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн ерөнхий үр дүн 6
II.2. “Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл” судалгааны дүн 6
II.3. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны дүн 21
III. Дүгнэлт 29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ 7
Хүснэгт 2. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ 8
Хүснэгт 3. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ 9
Хүснэгт 4. Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ 10
Хүснэгт 5. Улс төрчдийн төрийн байгууллагын зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийн үнэлгээ 11
Хүснэгт 6. Холбогдох үйл ажиллагаануудад улс төрийн хүрээний авлига чиглэгдэж буй байдлын үнэлгээ 11
Хүснэгт 7. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ 12
Хүснэгт 8. Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргуудын тархцын үнэлгээ 13
Хүснэгт 9. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын үнэлгээ 13
Хүснэгт 10. Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь 14
Хүснэгт 11. Төрийн байгууллагын зарим үйл ажиллагаан дахь авлигын тархцын үнэлгээ 15

Хүснэгт 12. Монгол Улс дахь улс төр болон бизнес, хууль хяналтын байгууллага, гэмт бүлэглэл, гадаадын улс төр, бизнесийн бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ 15
Хүснэгт 13. Монгол Улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ 16
Хүснэгт 14. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ 17
Хүснэгт 15: Хууль хяналтын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, салбараар 21
Хүснэгт 16. Хууль хяналтын байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар 21
Хүснэгт 17. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 22
Хүснэгт 18. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ 23
Хүснэгт 19. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтан өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ 24
Хүснэгт 20. Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахад хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ 24
Хүснэгт 21. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгч, авдаг хэлбэрүүдийн үнэлгээ 25
Хүснэгт 22. Авлигаар бий болсон хөрөнгийг зарцуулдаг хэлбэрүүдийн үнэлгээ 26
Хүснэгт 23. Хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн ач холбогдлын түвшин 27

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчийн төсөөллийн үзүүлэлт 6
Зураг 2. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 7

I. Судалгааны арга зүй

I.1. Судалгааны үндэслэл, зорилго

Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагын дээд хэмжээний уулзалтаас гаргасан Мянганы тунхаглалыг баталсан бусад улс орны нэгэн адил улс орныхоо хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг тусгасан Мянганы хөгжлийн үндэсний зорилго, зорилтуудыг тодорхойлсон. УИХ-аас 2005 онд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-уудыг батлахдаа үндсэн найман зорилгоос гадна хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авлигын эсрэг тэмцэхэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг нэмж баталсан.

Энэхүү зорилгын хүрээнд “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэсэн 24 дэх зорилтыг тавьсан бөгөөд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор энэхүү зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуурын нэгээр “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл” гэсэн үзүүлэлтийг тодорхойлж, холбогдох судалгааг явуулж, үр дүнг гаргаж мэдээлэх үүргийг Авлигатай тэмцэх газар (АТГ)-т даалгасан.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Мянганы хөгжлийн 9 дэх зорилтод дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн багтай хамтран боловсруулсан арга зүйн дагуу АТГ-аас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн судалгааг гурав дахь жилдээ явуулан үр дүнг нэгтгэн гаргаад байна.

Тус судалгаа нь улс төрийн болон хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг шинжээчдийн үнэлгээгээр тодорхойлж, энэ хүрээн дэх авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг өгөхөд чиглэгдсэн юм.

I.2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь дараахь агуулгыг илэрхийлэх тоон үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээ, тархалт;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигад өртөх эрсдэл бүхий түвшин, салбар, байгууллага;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалтгаан, нөхцөл;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төрөл, хэлбэр, хэмжээ.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа”-ны дүнд үндэслэн

тооцсон. Судалгааны асуулгад дээрх үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг авах, түүнчлэн, асуудлыг тайлбарлах нэмэлт асуултуудыг оруулсан.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа, бүрдүүлэгч дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээг 5 онооны хэмжээсээр гаргаж (тухайлбал: 1- огт үгүй, 5-маш их), дэд үзүүлэлтүүдийн энгийн арифметикийн дунджаар тооцсон болно.

Энэ удаагийн судалгаагаар Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг: улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт; хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт гэсэн байдлаар тус тусад нь тооцсон.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 7 бүлэг, 42 дэд үзүүлэлтээр, Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 6 бүлэг, 30 дэд үзүүлэлтээр тооцсон.

Энэхүү улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь зөвхөн судалгаанд хамрагдсан шинжээчдийн төсөөлөл, үнэлгээ, дүгнэлт гэдгийг энд дурьдах хэрэгтэй.

I.3. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ

Судалгаанд *Улс төрийн хүрээ* гэдэгт бүх шатны сонгуулийн үр дүнд байгуулагдсан байгууллага, албан тушаалтан, төрийн өндөр, дээд албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн бол *Хууль хяналтын байгууллагын хүрээ (шүүх эрх мэдлийн ба хууль сахиулах байгууллага)* гэдэгт шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн.

Судалгаанд оролцох шинжээчдийг сонгохдоо улс төрийн болон хууль хяналтын байгууллагад ажилласан туршлага, тухайн хүрээний талаарх мэдээ мэдээлэлтэй ажиллаж буй эсэх, тэдгээрт тулгуурласан судалгаа дүн шинжилгээний ажил хийдэг, түүнчлэн өмнөх судалгаануудад оролцож байсан эсэх зэрэг шалгуурыг харгалзан үзсэн. Энэ удаагийн судалгаанууд улс төрийн хүрээг үнэлэх 13, хууль хяналтын байгууллагын хүрээг үнэлэх 13, нийт 26 шинжээч оролцсон.

II. Судалгааны үр дүн

II.1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн ерөнхий үр дүн

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2011 онд 4.07 болж, 2010 оны түвшинд байсан байна (Зураг 1). Өөрөөр хэлбэл, шинжээчдийн үзэж байгаагаар улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын түвшин өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна.

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчийн төсөөллийн үзүүлэлт



Үүний дотор улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт 4.14 болж, 2010 оныхоос 0.01 пунктээр нэмэгдсэн бол хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт 3.95 болж 0.03 пунктээр буурчээ.

II.2. “Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл” судалгааны дүн

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2011 оны байдлаар улс төрийн хүрээн дэх авлигын тархцын үнэлгээ 4.58 буюу “ихээхэн түгээмэл” гарсан нь 2010 оныхоос 0.08 пунктээр өссөн байна.

Улс төрийн хүрээн дэх авлигад өртөмтгий байдлын үнэлгээгээр хууль тогтоох дээд байгууллага буюу УИХ – 3.75, төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг – 4.00, бүх шатны ИТХ – 3.55, нутгийн захиргааны байгууллага буюу бүх шатны Засаг даргын тамгын газар – 4.08, улс төрийн намууд 4.27 гэсэн тус тус үнэлэгдсэн байна. Улс төрийн институцуудын авлигад өртөмтгий байдлын 2011 оны дундаж үнэлгээ 3.82 байна. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ 2010 оныхоос нутгийн захиргааны байгууллага буюу бүх

шатны Засаг даргын тамгын газар, ИТХ болон улс төрийн намуудын хувьд 0.24-0.30 пунктээр нэмэгдсэн бол УИХ болон төрийн захиргааны байгууллага яам, агентлагийн хувьд 0.25-0.40 пунктээр буурчээ (Хүснэгт 2). Орон нутаг дахь нутгийн захиргааны байгууллага буюу Засаг даргын тамгын газар, Засаг дарга нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах болсныг энэхүү өөрчлөлт харуулж байна.

Хүснэгт 1. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ

	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
УИХ	3.71	4.46	4.00	3.75	-0.25
Ерөнхийлөгчийн тамгын газар	-	2.91	3.75	3.27	-0.48
Төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг	4.38	4.29	4.40	4.00	-0.40
Бүх шатны ИТХ	3.77	3.62	3.25	3.55	+0.30
Нутгийн захиргааны байгууллага буюу бүх шатны Засаг даргын тамгын газар	4.14	4.23	3.83	4.08	+0.24
Улс төрийн намууд	4.36	3.92	4.00	4.27	+0.27

Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өндөр байгаа төрийн захиргааны байгууллага дахь албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийг албан тушаалын түвшингээр нь авч үзвэл төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчдын буюу яам, агентлагийн газар, хэлтсийн болон салбар нэгжийн удирдлагуудын түвшинд 4.23 гэсэн үнэлгээгээр тэргүүлж байгаа бол түүний дараа төрийн захиргааны байгууллагын удирдлагын буюу сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд 4.08 гэсэн үнэлгээгээр удаалж байна (Зураг 2).

Зураг 2. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



Улс төрийн хүрээн дэх авлигад бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил (үнэлгээ 4.69), сонгуулийн санхүүжилтийн механизм (4.50), нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо (4.46), намын санхүүжилтийн механизм (4.38) зэрэг хүчин зүйлс хүчтэй нөлөөлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

Хүчин зүйлс	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2010-2009)
Одоогийн сонгуулийн тогтолцоо	4.14	4.10	3.83	3.45	-0.38
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.50	4.20	4.42	4.50	0.08
Намын санхүүжилтийн механизм	4.57	4.40	4.25	4.38	0.13
Улс төрийн томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.71	4.80	4.42	4.46	0.04
УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэнд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	4.30	3.83	4.33	0.50
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	3.90	3.50	4.00	0.50

Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн дотроос 2011 онд сонгуулийн тогтолцооны үнэлгээ 2010 оныхоос 0.38 пунктээр буурсан нь УИХ-ын сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, улс төрчид, олон нийтийн зүгээс сонгууль зохион байгуулах үйл явцтай холбоотой нааштай өөрчлөлтүүд орсон гэсэн хүлээлт байгааг харуулж байна. Гэвч уг хуулиар улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм асуудалтай хэвээр үлдсэн гэж шинжээчид үзжээ.

Улс төрийн хүрээн дэх авлигын гол шалтгаан болсон сонгуулийн болон намын санхүүжилтийн механизм, түүнийг дагасан улс төрийн томилгоо нь энэ хүрээний үндсэн оролцогч болох улс төрийн намууд авлигад автах үндсэн хүчин зүйл болж байна. Өнөөгийн улс төрийн болон сонгуулийн тогтолцооноос хамааран ямар ч улс төрийн нам авлигад автана гэдэгтэй судалгаанд оролцсон таван шинжээч тутмын гурав нь санал нийлжээ.

Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа албан тушаалд томилох (давтамжийн үнэлгээ 4.38), төрийн одон медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах

(4.25), мөнгө /хөрөнгө/ өгөх (4.15) зэрэг арга замуудыг харьцангуй олон давтамжтайгаар ашигладаг байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3-т дурдсан улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа хэрэглэж буй үйлдлүүдийн давтамжийн дундаж үнэлгээ 2010 онд 3.99 байсан бол 2011 онд 3.85 болж 0.14 пунктээр буурчээ.

Хүснэгт 3. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Албан тушаалд томилох	-	4.40	4.67	4.38	-0.28
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	-	3.80	4.36	4.25	-0.11
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.07	4.70	4.42	4.15	-0.26
Гадаад арга хэмжээний зардал даах	-	3.80	4.33	4.08	-0.25
Аялал, жуулчлалын зардал даах	3.33	3.90	4.09	4.08	-0.01
Бэлэг сэлт өгөх	3.73	4.70	4.45	4.00	-0.45
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.80	4.20	4.36	4.00	-0.36
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	-	4.00	4.00	4.00	0.00
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	-	4.10	3.89	3.92	0.03
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	-	4.30	4.11	3.83	-0.28
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	-	3.50	3.56	3.80	0.24
Сургалтын зардал даах	-	3.80	3.83	3.77	-0.06
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	-	3.60	3.56	3.73	0.17
Эмчилгээ, сувилгааны зардал даах	-	3.60	3.82	3.60	-0.22
Хувьцаа өгөх өгөх	-	2.70	3.33	3.36	0.03
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	-	2.90	3.63	3.33	-0.29
Өрийг нь төлөх	-	2.80	3.45	3.22	-0.23
Дундаж үнэлгээ		**3.81**	**3.99**	**3.85**	**-0.14**

Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөхдөө голчлон албан тушаалтны зөрчлийг нь илрүүлж, түүгээр нь дарамтлах (тархцын үнэлгээ 4.00), дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэтээр/ (4.00) зэрэг үйлдлийг голчлон хэрэглэдэг байна. Гэхдээ төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх доорх үйлдлүүдийн

тархцын дундаж үнэлгээ 3.85 байгаа нь 2010 оныхоос 0.14 пунктээр буурчээ (Хүснэгт 4).

Хүснэгт 3 болон Хүснэгт 4-д гарсан судалгааны үр дүн улс төрийн хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс шууд нөлөөлөх байдал харьцангуй буурч, шууд бус аргуудыг хэрэглэх явдал нэмэгдсэн болохыг харуулж байна.

Хүснэгт 4. Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	-	4.40	4.09	4.00	-0.09
Дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэт/	3.64	4.00	3.83	4.00	0.17
Хууль бус шаардлага тавих	-	3.60	3.67	3.92	0.25
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	-	3.70	3.67	3.91	0.24
Бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх	-	3.90	3.70	3.75	0.05
Шан харамж нэхэх	3.43	3.90	3.27	3.50	0.23
Дундаж үнэлгээ	**-**	**3.92**	**3.71**	**3.85**	**0.14**

Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд (2008-2011 оны хооронд) улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд голчлон ажил албан тушаалд томилох, тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад голчлон нөлөөлж байжээ. Улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх давтамж 2011 онд 2010 онтой харьцуулахад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх (0.41 пунктээр нэмэгдсэн), шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх (0.30), хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх (0.23) чиглэлээр илүү идэвхжсэн байна. Сонгогдсон үйл ажиллагаануудад нөлөөлөх давтамжийн дундаж үнэлгээ 2009 онд 4.11 байсан бол 2010 онд 4.34, 2011 онд 4.43 болж нэмэгдсэн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Улс төрчдийн төрийн байгууллагын зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Ажил, албан тушаалд томилох ажиллагаанд нөлөөлөх	4.79	4.60	4.64	4.67	0.03
Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах	4.57	4.50	4.45	4.58	0.13
Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3.79	4.00	4.27	4.50	0.23
Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3.67	3.90	4.20	4.50	0.30
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4.00	4.10	4.09	4.50	0.41
Хууль, эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаанд	4.00	3.90	4.18	4.33	0.15
Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх	3.47	3.60	4.56	4.18	-0.37
Төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх	4.00	4.30	4.36	4.15	-0.21
Дундаж үнэлгээ	**4.04**	**4.11**	**4.34**	**4.43**	**0.08**

Шинжээчдийн үзэж байгаагаар улс төрийн авлига уул уурхайн салбар болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл (тус бүр 4.54 гэсэн үнэлгээтэй), намд эрх мэдлээ тогтоох (4.33)-д түлхүү чиглэгддэг байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Холбогдох үйл ажиллагаануудад улс төрийн хүрээний авлига чиглэгдэж буй байдлын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Уул уурхайн салбар	4.67	4.42	4.54	0.12
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4.38	4.27	4.54	0.27
Намд эрх мэдлээ тогтоох	4.55	4.42	4.33	-0.09
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.50	4.17	4.30	0.13
Орон сууц, барилга байгууламж барихад	4.08	3.92	4.23	0.31
Өмч хувьчлал	3.73	4.10	4.20	0.10
Гадаадын хөрөнгө оруулалт	3.82	3.92	4.17	0.25
Бизнест эрх мэдлээ тогтоох	4.27	4.45	3.92	-0.53
Газар тариалан	3.60	3.00	3.25	0.25
Дундаж үнэлгээ	**4.18**	**4.07**	**4.16**	**0.09**

Улс төрийн хүрээнд мөнгө угаах (тархцын үнэлгээ 4.67), намд хандив авах (4.62), улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах (4.38) зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Мөнгө угаах	4.00	3.80	4.67	0.87
Намд хандив авах	4.42	4.25	4.62	0.37
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах	4.42	4.50	4.38	-0.12
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.33	4.64	4.33	-0.30
Сонгогчдын саналыг худалдан авах	4.69	4.50	4.31	-0.19
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.54	4.58	4.23	-0.35
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	4.46	3.25	4.15	0.90
Төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа завших	4.00	4.00	4.08	0.08
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхолоор зарцуулах	4.15	4.36	4.08	-0.29
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.00	4.17	3.91	-0.26
Хууль бусаар дампууруулах	3.56	3.56	3.78	0.22
Хувийн байгууллага, санд хандив авах	3.75	3.64	3.73	0.09
Дундаж үнэлгээ	**4.19**	**4.10**	**4.19**	**0.09**

Өмнөх жилүүдэд бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байсан бол 2012 онд УИХ-ын болон орон нутгийн сонгууль болохтой холбоотойгоор дээрх байдлаар олсон орлогоо сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулахаар хувиргах, сонгуулийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бий болгоход анхаарлаа хандуулах болсон байна. Иймд нэр дэвших болон сонгуулийн санхүүжилтэд зарцуулж буй хөрөнгийн үүслийг нарийн шалгах шаардлагатай байна.

Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авахдаа зуучлагчаар дамжуулах (4.00), ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох (3.90) зэрэг аргууд илүү өргөн тархсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах болон зах

зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах зэрэг аргуудын тархац 0.25-0.32 пунктээр нэмэгджээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргуудын тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Зуучлагчаар дамжуулах	4.10	4.09	4.00	-0.09
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.20	4.08	3.90	-0.18
Мөрийтэй тоглож санаатай алдах	3.44	3.75	3.90	0.15
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.56	3.55	3.80	0.25
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.50	3.45	3.78	0.32
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.89	3.75	3.75	0.00
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.36	4.27	3.50	-0.77
Мөнгө зээлдүүлээд мартах	3.00	3.56	3.40	-0.16
Шууд өөрт нь өгөх	3.45	3.80	3.33	-0.47
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.08	4.22	3.18	-1.04
Дундаж үнэлгээ	**3.66**	**3.85**	**3.65**	**-0.20**

Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө ихэвчлэн орон сууц худалдан авах (тархцын үнэлгээ 4.82), хүүхдийнхээ сургалтын төлбөрт болон машин, үл хөдлөх хөрөнгө худалдан авах (4.80)-д зарцуулдаг байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулах (тархцын үнэлгээ 2010 оныхоос 0.51 пунктээр нэмэгдсэн), орон сууц худалдан авах (0.36 пунктээр) машин, үл хөдлөх хөрөнгө худалдан авах (тус бүр 0.35 пунктээр) зэрэг хэлбэрүүдийн тархац илүү нэмэгдсэн байна (Хүснэгт 9).

Энэхүү үнэлгээ нь АТГ-ын зүгээс албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгт хийх хяналт шалгалтыг ажлыг юунд хандуулах ёстойг харуулж байна гэж үзэж байна.

Хүснэгт 9. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хэлбэрүүд / хариулт	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Орон сууц худалдан авдаг	4.82	4.45	4.82	0.36
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.60	4.82	4.80	-0.02
Машин худалдан авдаг	4.45	4.45	4.80	0.35
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.82	4.45	4.80	0.35

Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.60	4.27	4.78	0.51
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.40	4.20	4.45	0.25
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.33	4.64	4.40	-0.24
Дараагийн сонгуульд зарцуулах	3.25	4.00	3.60	-0.40
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.40	3.44	3.25	-0.19
Хувьцаа худалдан авдаг	3.00	3.67	3.22	-0.44
Гадаадын банкинд хадгалдаг	3.44	4.00	3.00	-1.00
Дотоодын банкинд хадгалдаг	4.00	3.67	3.00	-0.67
Дундаж үнэлгээ	**4.09**	**4.17**	**4.08**	**-0.10**

Шинжээчдийн үзэж байгаагаар бизнес эрхлэгчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхдээ дунджаар татвар ногдох дүнгийн 15.3 хувийг, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэхдээ нэхэмжлэлийн дүнгийн 14.6 хувийг, зээл авахдаа зээлийн дүнгийн 11.0 хувийг, өмч хувьчлах шийдвэр гаргуулахдаа хувьчлах хөрөнгийн үнийн дүнгийн 16.9 хувийг, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялахын тулд тендерийн дүнгийн 12.5 хувийг, төсөл, хөтөлбөрт хамрагдахдаа төсөл хөтөлбөрийн төсвийн 12.0 хувийг авлигатай холбоотойгоор зарцуулдаг байна (Хүснэгт 10). Судалгааны дүнгээс харахад 2010 онтой харьцуулахад 2011 онд бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн нийт үнийн дүнд эзлэх хувь татвараас чөлөөлүүлэх, өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх, зээл авах, өмч хувьчлах шийдвэр гаргуулах зэрэг хэлцлүүд дээр 1.0-3.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь

Ажил үйлчилгээ / Үнийн дүнгийн хувь	2009	2010	2011
Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	12.45	12.91	12.00
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах	16.50	13.41	12.50
Өмч хувьчлах шийдвэр гаргуулах	15.78	15.83	16.94
Зээл авах	11.50	10.00	11.00
Өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх	11.08	11.00	14.64
Татвараас чөлөөлүүлэх	15.50	11.39	15.28

Ажил, албан тушаалд ороход дунджаар 16.1 сая төгрөгийг, тусгай зөвшөөрөл авахад дунджаар 15.5 сая төгрөгийг, ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулахад дунджаар 22.1 сая төгрөгийг тус тус авлигад зарцуулдаг гэж шинжээчид үзжээ. Авлигын өртөг 2010 оныхоос нэмэгдсэн байна.

Шинжээчид төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (авлигын тархцын үнэлгээ 4.54), төрийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох (4.46) зэрэг үйл ажиллагаанд авлига их тархсан гэж үзэж байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Төрийн байгууллагын зарим үйл ажиллагаан дахь авлигын тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2010-2009)
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	4.80	4.54	4.75	4.54	-0.21
Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа	4.80	4.69	4.83	4.46	-0.37
Ажил, албан тушаалд томилох	4.53	4.46	4.50	4.31	-0.19
Өмч хувьчлал	3.87	3.82	4.50	4.00	-0.50
Төсөл, хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэх ажиллагаа	4.13	4.08	4.25	3.85	-0.40
Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа	3.80	4.00	4.20	3.85	-0.35
Төрийн өмч, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах	4.27	4.38	4.42	3.67	-0.75
Дундаж үнэлгээ	**4.31**	**4.28**	**4.49**	**4.10**	**-0.40**

Өмнөх судалгаагаар шинжээчид бүгд 100.0 хувь улс төрийн авлига илүү далд шинжтэй болсон гэдэгтэй санал нийлж байсан бол энэ үзүүлэлт 84.6 хувь болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, зарим талаар улс төрийн авлига ил цагаандаа гарах болсон байна гэдгийг энэ үр дүн харуулж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар бизнесийн бүлэглэлийн зүгээс улс төрчдийг эрхшээлдээ оруулах явдал 2011 онд илүү эрчимжсэн байна (Хүснэгт 12). Энэ нь сонгуулийн хугацаа ойртож, улс төрчид рүү чиглэсэн бизнесийн бүлэглэйнхний лобби болон бусад нөлөөллийн үр ажиллагаа эрчимжиж байгаатай холбоотой.

Хүснэгт 12. Монгол Улс дахь улс төр болон бизнес, хууль хяналтын байгууллага, гэмт бүлэглэл, гадаадын улс төр, бизнесийн бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ

Үзүүлэлт	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Улс төрчид бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	2.23	3.50	2.83	-0.67
Бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулсан	4.69	4.50	4.69	0.19
Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.67	4.67	4.33	-0.33
Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэл /мафи/-ийг гартаа оруулсан	2.40	2.78	2.11	-0.67

Улс төрийн нам /бүлэглэл/-ыг гэмт бүлэглэл /мафи/ гартаа оруулсан	2.80	3.40	2.83	-0.57
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	3.18	3.73	3.00	-0.73
Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	4.11	3.91	2.64	-1.27
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	2.78	3.60	2.00	-1.60
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	1.22	1.40	1.55	0.15
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	1.20	3.00	3.20	0.20
Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.67	5.00	4.23	-0.77
Улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлсэн	4.08	4.50	4.54	0.04

Монгол Улсад хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон болон найз нөхдийн хүрээлэл шинжээчдийн үзэж байгаагаар 2010 онтой харьцуулахад илүү эрчимжсэн байна. Харин нам тойрсон хүрээллийн үйл ажиллагааны хүч бага буурсан байна. Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл хүч султай хэвээр байна (Хүснэгт 13). Эдгээр бүлэглэлүүдээс хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан бизнесийн хүрээлэл хамгийн хүчтэй болох нь харагдаж байна.

Хүснэгт 13. Монгол Улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ

Бүлэглэлүүд / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2010-2009)
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон хүрээлэл	3.77	4.00	3.69	-0.31
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл	4.31	4.75	4.08	-0.67
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, бизнесийн хүрээлэл	4.42	4.58	4.31	-0.27
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам дамжсан хүрээлэл /намуудын нэгдэл/	4.38	4.42	4.08	-0.34
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээлэл	4.00	4.08	4.31	0.23

Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, найз нөхдийн хүрээлэл	3.92	3.75	3.77	0.02
Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	1.82	2.27	2.08	-0.19
Дундаж үнэлгээ	**3.80**	**3.98**	**3.76**	**-0.22**

Шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагад авлига оршин байхад хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.54), хуулийн хэрэгжилтэд тавих хяналт (4.46), олон шат дамжлага, давхардал (4.31) зэрэг хүчин зүйл илүү хүчтэй нөлөөлдөг байна (Хүснэгт 12). Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн хэрэгжилт, хариуцлага тооцох механизм сул байгаа нь авлига үүсэх гол хүчин зүйл солж байна.

Хүснэгт 14. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.62	4.33	4.54	0.21
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4.40	4.15	4.75	4.46	-0.29
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.54	4.75	4.31	-0.44
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчид тавих хяналт сул	4.00	4.17	4.58	4.23	-0.35
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.23	4.33	4.23	-0.10
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадвар дутагдалтай	4.27	4.08	4.33	4.15	-0.18
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.38	4.58	4.08	-0.51
Хүнд суртал	4.47	4.75	4.67	4.00	-0.67
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.38	4.58	4.00	-0.58
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.47	4.00	4.17	4.00	-0.17
Дундаж үнэлгээ	**4.27**	**4.33**	**4.51**	**4.20**	**-0.31**

Авлигыг бууруулахад ямар арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай талаарх асуултад намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх гэсэн санаа 18.4 хувийн, шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох гэсэн санаа 15.8 хувийн, улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл,

зоригийг нэмэгдүүлэх гэсэн санаа 13.8 хувийн санал авсан нь голлох санаанууд болж байна.

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад дээр дурдсан арга хэмжээнүүдээс гадна дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Санал болгож буй арга хэмжээнүүд	**Тэдгээрийг хэрэгжүүлэх арга замууд**
• Авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгох, нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх	• Ёс зүйт орчинг төрийн бүх салбарт адил тэгш нэвтрүүлэх • Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй явуулах, авлигын томоохон тодорхой хэргүүдийг шүүхээр шийдүүлэн авлига эрсдэлтэй зүйл гэдгийг улс төрчдөд ойлгуулах
• Төрийн болон олон нийтийн өмчийн тухай хууль гаргах • Иргэний болон эрүүгийн хууль дахь төрийн өмчтэй холбогдох хэсгийг дэлгэрэнгүй болгох • Төрийн өмчийн прокурор бий болгох	• Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, үүний тулд иргэдэд татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх • Төрийн байгууллагын бараа, үйлчилгээнд зарцуулсан НӨАТ-ыг 100 хувь буцааж өгдөг байх. Энэ нь тендер дагасан хахуулийг устгана. • Сүүлийн 5-н жилд татварын хуульд орсон өөрчлөлтүүдийг батлуулахад оролцсон УИХ-ын гишүүд, түүнтэй холбоотой бизнесийн үйл ажиллагааг судлан үзэх хэрэгтэй байна. Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг газар дээр нь шууд шалгаж, хөрөнгийн эх үүсвэрийг нь баталгаажуулах шаардлагатай.
• Хамгийн түрүүнд цагдааг авлигагүй болгох, Хонконгийн туршлагыг хэрэгжүүлэх • Сайд дарга нарын тансаг хэрэгцээнд хуулиар хязгаарлалт хийх • Дарга нарын тоог цөөлж иргэдэд үйлчилдэг хэсгийг өргөжүүлэх	• Хэвлэлээр гарсан шүүмжлэлийн мөрөөр шалгадаг арга хэмжээ авдаг хуулийн тогтолцоо бий болгох • Алдаа гаргасан, иргэдийг гомдоосон албан тушаалтныг төрийн албанд дахин ажиллуулахгүй байх • Хөрөнгө орлогын мэдүүлгийг сайн шалгахаас гадна нийтэд ил тод болгох
• Шүүх хараат бус байх нөхцөлийг бүрдүүлэх	• Хууль хяналтын байгууллагынхныг улс төр, бизнесийнхнээс хараат байдлаас салгах бүхий л арга хэмжээг авах
• Улсын төсвийг шударга зохиож авлига нуугдах боломжийг хаах	• Улсын төсөвийг батлахдаа УИХ-ын гишүүдийн саналаар биш алс

• Аливаа шийдвэр болон төрийн мөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааг ил тод явуулах, олон нийтийн хяналтыг сайжруулах	хэтийн төлөвлөлтийг үндэслэн санхүүжүүлэх обьектийн дараалалыг ҮАБЗ-өөр тогтоосон байх, • Аливаа тендерийг явуулахдаа хамгийн бага үнээр биш харин дэлхийн жишигт хийцсэн хамгийн сайн бүтээгдэхүүнээр бодитоор үнэлэх • Мэдээллийн нээлттэй байдлыг дэмжих • Төрийн албан хаагчдын цалинг нэмж шударга ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
• Хэрэг хийсэн хээл хахууль авсан л бол шийтгэж байх • Төрийн албаны боловсон хүчний бодлогыг шат дараалан гүйцэтгэдэг журам тогтоох • Улс төрчдийн хувьд ёс зүйг эрхэмлэдэг жишиг тогтоох • Мэдлэг чадвар, туршлага, шударга байдлыг томилгооны гол шалгуур болгох • Уламжлалт зан заншил, ёс суртахууны хүмүүжил соён гэгээрүүлэх ажлыг сайн хийж хууль зөрчихөөс нь өмнө ёс суртахууны зөрчил гаргасан, нэр нь холбогдсон албан тушаалтанд ёс зүйн хариуцлага тооцож албан тушаалаас нь өөрчилдөг байх • Авлигад өртгөмтгий албан тушаалд ёс зүйтэй шударга 45-аас дээш насны хүмүүсийг томилох	• Төрийн албаны томилгооноос эхлэх шаардлагатай. Дүрэм журмын дагуу явагдаж буй эсэхэд Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гаргадаг болох. • Боловсон хүчнийг томилохдоо шат алгасаж улс төрийн томилгоо хийдэгийг болих. • Ёс суртахууны зөрчил гаргасан, нэр холбогдсон албан тушаалтныг ажлаас нь өөрчилдөг болох
• Лоббиг зохицуулах тухай хууль гаргах	• Лобби бүлгийг ил тод мэдээлж зарлах • Хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах, хянах • Сонгуулийн авлигыг тусгайлан авч үзэж бууруулах • Улс төрчид сонгогчдын саналыг татаж буй арга нь авлига үүсгэж байгааг зогсоох
• Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (2011 оны 6 сард батлагдсан) хуулийн хэрэгжилт сайжруулах, хэвлэл мэдээллх үзэж бу	

газар				
Прокурорын байгууллагын дундаж үнэлгээ	**3.12**	**3.75**	**3.40**	**-0.35**
Мөрдөн байцаагч	3.82	3.75	3.73	-0.02
Хэрэг бүртгэгч	3.55	3.50	3.89	0.39
Эрүүгийн цагдаа	3.82	3.50	3.70	0.20
Хэв журмын цагдаа	2.91	3.45	3.30	-0.15
Замын цагдаа	3.82	3.83	3.91	0.08
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	2.63	-0.19
Цагдаагийн байгууллагын дундаж үнэлгээ	**3.50**	**3.48**	**3.53**	**0.05**
Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3.45	3.70	3.80	0.10
Хорих ял эдлүүлэх алба	3.36	3.20	3.70	0.50
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	3.00	0.00
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундаж үнэлгээ	**3.21**	**3.30**	**3.50**	0.20

Шинжээчдийн үзэж байгаагаар хууль хяналтын байгууллагад холбогдох үйл ажиллагаануудаас ялтныг урамшуулах /шагналын хоног олгох/ (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 4.44), өр барагдуулах (4.20), эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх болон ялын хэмжээг бууруулах (4.11), эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах (4.10) зэрэг үйл ажиллагаанд авлигад өртөх харьцангуй өндөр байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Үйл ажиллагаа / эрсдлийн үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Ялтныг урамшуулах /шагналын хоног олгох/	3.11	3.63	4.44	0.82
Өр барагдуулах	-	4.00	4.20	0.20
Эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх	-	3.78	4.11	0.33
Ялын хэмжээг бууруулах	3.60	4.00	4.11	0.11
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58	4.00	4.10	0.10
Хорих ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах	-	4.13	4.00	-0.13
Шүүхийн шийдвэрийг хурдан гүйцэтгэх	3.56	3.71	4.00	0.29
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64	4.40	3.91	-0.49
Хорих ангид ялтан хуваарилах	3.25	3.67	3.90	0.23

Эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэх	3.64	3.90	3.89	-0.01
Эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх	3.27	3.88	3.89	0.01
Эрүүгийн хэрэг яллахаас татгалзах	3.18	3.45	3.80	0.35
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах	3.22	4.09	3.78	-0.31
Эрүүгийн хэрэг үүсгэх үйл ажиллагаа	3.90	3.92	3.67	-0.26
Албадан дуудлага худалдаанд оруулах	3.22	3.13	3.67	0.54
Торгууль ногдуулах	3.36	3.75	3.63	-0.13
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх	3.40	3.50	3.55	0.05
Хорих ял эдлүүлэх	-	3.30	3.50	0.20
Тодорхой хугацаагаар эрх хасах	-	3.83	3.44	-0.39
Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх	3.00	3.38	3.44	0.07
Прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх	3.33	3.70	3.44	-0.26
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27	3.44	3.22	-0.22
Дундаж үнэлгээ	**3.38**	**3.75**	**3.80**	**0.05**

Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.40), хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмийн дутагдалтай байдал (4.33), хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөлийн хангалтгүй байдал (4.27) зэрэг хүчин зүйлсийн хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсгэх нөлөөллийн үнэлгээ харьцангуй өндөр байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ

Хүчин зүйлс / нөлөөлөл	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.64	3.75	3.92	0.17
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал	-	3.42	3.64	4.00	0.36
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	-	3.67	4.00	4.40	0.40

Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4.00	4.00	4.27	0.27
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.2	3.73	4.00	4.33	0.33
Дундаж үнэлгээ	**3.92**	**3.69**	**3.88**	**4.18**	**0.31**

Албан тушаалтны зөрчлийг илрүүлж, түүгээр нь дарамтлах байдал хууль хяналтын байгууллагынхны дунд нийтлэг болсон (тархцын үнэлгээ 4.33) арга хэлбэр болж байна. Хууль хяналтын байгууллагын албан тушаалд дарамт шахалт үзүүлэх байдлын үнэлгээ 2010 онд 3.58 байсан бол 2011 онд 3.82 болж 0.23 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтан өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Оролцох нөлөөлөх хэлбэр / тархац	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.00	4.22	4.33	0.11
Дарамт шахалт үзүүлэх	3.64	3.58	3.82	0.23
Хууль бус шаардлага тавих	3.67	3.85	3.70	-0.15
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	3.42	3.83	3.70	-0.13
Шан харамж нэхэх	3.00	3.13	3.38	0.25
Дундаж үнэлгээ	**3.55**	**3.72**	**3.79**	**0.06**

Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа мөнгө, хөрөнгө өгөх (давтамжийн үнэлгээ 4.44), улс төрийн хамгаалалтад авах (4.29), төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах болон хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох (4.00) зэрэг аргуудыг голчлон хэрэглэдэг байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахад хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08	4.08	4.44	0.37
Улс төрийн хамгаалалтанд авах	2.83	4.14	4.29	0.14

Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	3.14	3.71	4.00	0.29
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.00	3.25	4.00	0.75
Бэлэг сэлт өгөх	4.08	4.09	3.90	-0.19
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	2.89	4.22	3.88	-0.35
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.30	4.00	3.86	-0.14
Албан тушаалд томилох	3.60	3.73	3.80	0.07
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	1.67	2.50	3.67	1.17
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	3.70	3.00	3.50	0.50
Өрийг нь төлөх	3.33	3.75	3.44	-0.31
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	3.11	3.83	3.38	-0.46
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	2.50	3.40	3.33	-0.07
Гадаад арга хэмжээний зардал даах	2.50	3.75	3.17	-0.58
Хувьцаа өгөх	2.00	3.00	3.00	0.00
Сургалтын зардал даах	2.63	3.25	2.86	-0.39
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63	3.17	2.71	-0.45
Аялал, жуулчлалын зардал даах	2.91	3.38	2.57	-0.80
Дундаж үнэлгээ	**2.99**	**3.57**	**3.54**	**-0.03**

Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 13.6 сая төгрөгийн, хэрэг бүртгэх мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 9.2 сая төгрөгийн, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад дунджаар 11.8 сая төгрөгийн, эрүүгийн хэрэг үүсгэхэд дунджаар 6.4 сая төгрөгийн хээл хахууль өгдөг өгдөг гэж шинжээчид үзжээ.

Хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд хээл хахууль өгөхдөө зуучлагчаар дамжуулах (4.20), өмгөөлөгчөөр дамжуулах (4.11) хэлбэрийг илүү түлхүү хэрэглэдэг байна (Хүснэгт 21). Доорх бүх хэлбэрийн давтамж, тархац 2010 онтой харьцуулахад нэмэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт 21. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгч, авдаг хэлбэрүүдийн үнэлгээ

Хэлбэрүүд	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Зуучлагчаар дамжуулах	3.60	3.73	4.20	0.47
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.80	3.82	4.11	0.29

Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	3.33	3.33	3.88	0.55
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.00	3.17	3.86	0.69
Мөрийтэй тоглож санаатайгаар алдах	2.78	3.63	3.75	0.12
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.00	3.22	3.67	0.45
Шууд өөрт нь өгөх	2.90	3.17	3.64	0.47
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.00	3.14	3.63	0.49
Мөнгө зээлдүүлээд мартах	3.44	3.57	3.63	0.06
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29	2.80	2.86	0.06
Дундаж үнэлгээ	**3.11**	**3.36**	**3.72**	**0.36**

Хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд авлигаар бий болгосон хөрөнгөө голчлон өдөр дутмын хэрэгцээндээ болон хүүхдийн сургалтын төлбөртөө зориулах (үнэлгээ 5.00) буюу машин, орон сууц худалдан авах (4.78)-д зарцуулдаг байна (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Авлигаар бий болсон хөрөнгийг зарцуулдаг хэлбэрүүдийн үнэлгээ

Хэлбэрүүд	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.75	4.78	5.00	0.22
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	3.33	4.50	5.00	0.50
Машин худалдан авдаг	5.00	4.56	4.78	0.22
Орон сууц худалдан авдаг	3.33	4.56	4.78	0.22
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5.00	4.25	4.75	0.50
Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.00	4.78	4.50	-0.28
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	3.00	3.67	4.43	0.76
Дотоодын банкинд хадгалдаг	3.25	3.00	4.00	1.00
Хувьцаа худалдан авдаг	2.83	3.00	3.86	0.86
Гадаадын банкинд хадгалдаг	2.64	3.00	3.80	0.80
Дундаж үнэлгээ	**3.81**	**4.01**	**4.49**	**0.48**

Шинжээчид хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад нэн тэргүүнд АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах (4.83), хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах (4.82), албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах шударга ил тод механизм бий болгох (4.73) зэрэг хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн ач холбогдлын түвшин

Арга хэмжээ / ач холбогдлын түвшин	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	4.38	4.83	0.45
Хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах	4.33	4.82	0.48
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах, шударга ил тод механизм бий болгох	4.42	4.73	0.31
Хууль хяналтын байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх	4.58	4.67	0.08
Авлигачдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагын арга хэмжээг чангатгах	4.36	4.67	0.30
Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх	4.64	4.58	-0.05
Ур чадварт үндэслэн томилгоо хийх	4.62	4.55	-0.07
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын ёс зүй, ажлын доголдлыг тооцож хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх	4.67	4.45	-0.21
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын хууль зүйн баталгааг сайжруулах	4.50	4.45	-0.05
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх	4.55	4.42	-0.13
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг сэлгэн ажиллуулах	4.00	4.36	0.36
Иргэний нийгмийг өргөн хүрээнд оролцуулах	4.09	4.08	-0.01
Дундаж үнэлгээ	**4.43**	**4.55**	**0.12**

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай дараахь арга замуудыг илэрхийлсэн. Үүнд:

- Хээл хахууль авсан хүнд ногдуулах шийтгэлийг чангатгаж, өгсөн этгээдийг өөрөө хэргээ илчлэн ирсэн тохиолдолд хариуцлагаас чөлөөлж байх. Ингэснээр авлигын гэмт хэргийн илрүүлэлт сайжирч, хээл хахууль авах нь багасна гэж үзэж байна.
- АТГ-ын хараат бус, бие даасан байдлыг баталгаажуулах.
- Хуулийг боловсронгуй болгож, хуулийн хэрэгжилтийг сайжруулах.
- Ил тод байдлыг нэмэгдүүлэх. Уг ажлыг хууль тогтоох дээд байгууллага УИХ- аас өөрөөс нь эхлэх.
- Ажиглалтын аргыг хэрэгжүүлж, үндэслэлгүй баяжсан төрийн албан хаагчдын хөрөнгийг хураах.
- Урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд үр дүнтэй зохион байгуулах.
- Төрийн албаны томилгоог боловсронгуй болгох.

- Алба тушаалтнуудын үүрэг хариуцлагын тогтолцоо механизмыг сайжруулах хүний эрх, эрх чөлөөг хангах зарчим дээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд шинэтгэл хийх.
- Нийгмийн бүх давхарга дахь олон нийтийн авлигын талаарх ойлголт, ухамсрыг дээшлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх.
- Хууль хяналтын байгууллагын удирдах ажилтны томилгоог улс төрөөс ангид болгож яамдын төрийн нарийн бичгийн дарга нар томилдог болох.
- Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг ил тодоор ур чадвар туршлага мэдлэг суурилсан сонгон шалгаруулалтаар томилох төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх. Албан тушаал зардаг явдлыг зогсоох, улсын мөнгөөр бизнес хийх зорилготой хүмүүст зориуд бололцоо олгож,томилгоо хийдэг явдлыг таслан зогсоох.
- Ашиг сонирхолын зөрчлийг мэдээлэх журамд яаралтай шилжүүлэх.
- Авлигын хэргийг шалгах шийдвэрлэх эрх бүхий дагнасан мэргэшсэн бүтэц бүрэлдэхүүнийг бий болгох. Авлигын хэргийг мөрдөн шалгах илрүүлэн эрх бүхий байгууллагын уялдаа харилцан хамтран ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Хуулийн ажилтны үйлдсэн авлигын хэргийг УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж байгаа тул гүйцэтгэх ажилтны эрх олгох. Тэднийг энэ чиглэлийн сургалтанд хамруулах.
- Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт сэлтийг нотлох ажиллагаанд ашиглах аргачлалыг боловсруулж, үр нөлөөг дээшлүүлэх.
- Зөвшөөрлийн аливаа системд хяналт тавих.

Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд оролцсон шинжээчдийн хувьд судалгааны үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний үр дүнг олон нийтэд мэдээлж байх шаардлагатай гэж үзэж байна.

III. Дүгнэлт

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн дөрөв дэхь удаагийн судалгааг явуулж, үр дүнг нэгтгэн гаргаж, та бүхэнд танилцуулж байна. Энэхүү судалгааг дөрвөн жил дараалан явуулснаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдлын өөрчлөлт, хөдөлгөөнийг тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгож байгаа юм.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд улс төрийн бүх шатны байгууллага, сонгуулийн үр дүнд байгууллагддаг бүх шатны байгууллага, хэвлэл, мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг; Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд хууль хяналтын байгууллагын бүх салбар, түвшний төрийн байгууллага, иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг сонгож оролцуулсан нь тооны хувьд цөөн шинжээч оролцсон хэдий ч өргөн хүрээтэй мэдлэг, мэдээлэл бүхий шинжээчдийг оролцуулан нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч чадсан гэж дүгнэж байна.

Судалгаагаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдал, цаг хугацааны өөрчлөлтийг тодорхойлохын зэрэгцээ энэ хүрээнд аль түвшинд нь авлигын эрсдэл өндөр байгаа, улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлига аль салбар, үйл ажиллагаа голлон чиглэгдэж байгаа, авлигыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөлүүд, авлига, хээл хахуулийг ямар хэлбэрээр хэрэгжүүлж байгаа, авлигаар бий болгосон хөрөнгөө юунд, хэрхэн зарцуулж байгаа, хэдий хэр хэмжээний хөрөнгө авлигатай холбоотойгоор эргэлдэж байгаа зэрэг өргөн хүрээтэй мэдээллийг эндээс олж авах боломжтой.

Судалгааны үр дүн гагцхүү судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлэлт, төсөөлөл бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн дараахь дүгнэлт, зөвлөмжийг өгч байна.

- Шинжээчдийн үзэж байгаагаар 2011 онд улс төрийн хүрээн дэх авлигын үзүүлэлт өмнөх оноос нэмэгдсэн бол хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үзүүлэлт бага зэрэг буурчээ. Энэ хүрээн дэх авлигын үзүүлэлт төдийлөн өөрчлөгдөхгүй байна.
- Өнгөрсөн онд 2010 онтой харьцуулахад бүх шатны ИТХ, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаан дахь авлигын эрсдэл нэмэгджээ. Энэ нь орон нутаг дахь нутгийн захиргааны байгуулага буюу Засаг даргын тамгын газар, Засаг дарга нарын үл ажиллагаанд чиглүүлсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай болсныг харуулж байна.
- Төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчид буюу газар, хэлтсийн дарга нар авлигад өртөх эрсдэл илүү байгааг анхаарч үзэх нь зүйтэй.
- Энэ хүрээн дэх авлигыг бууруулахад чухал шаардлагатай эрх зүйн зохицуулалт болох ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь чухал алхам болсон. Энэхүү зохицуулалт нь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигыг үүсгэх нэг шалтгаан болж буй бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлыг хязгаарлах чухал алхам байх болно. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй.
- УИХ-ын сонгуулийн тухай хууль батлагдснаар сонгуулийн болон улс төрийн авлигыг таслан зогсооход чухал алхам болсон хэдий ч улс төрийн хүрээн дэх авлигын үндсэн шалтгаан болсон улс төрийн

намын болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.

- Улс төрийн намын болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн зохицуулалтын дараа авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ бол зэрэгцээ лобби үйл ажиллагаа ил тод болгох, зохицуулах асуудал болж байна.
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үйлдлийг ямар арга замаар хэрэгжүүлдэг, хэрхэн төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлдөг, төрийн байгууллагын ямар үйл ажиллагаа, салбар руу авлига чиглэгдэж, хэрхэн хээл хахуулийг өгч, авдаг авлигаар олсон хөрөнгийг юунд зарцуулдаг болох зэрэг авлигын хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, таслан зогсоох, хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийхэд анхааралдаа авах шаардлагатай мэдээллийг энэхүү судалгаа өгч байна. Иймд АТГ-ын холбогдох хэлтэс, албад судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өөрсдийн үйл ажиллагаандаа авч ашиглах нь зүйтэй.
- Иргэний болон эрүүгийн хууль дахь төрийн болон олон нийтийн өмчтэй холбогдох заалтуудыг тодорхой болгох, нарийвчлан авч үзэх, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд төрийг төлөөлөх үүргийн хэрэгжилтийг дээшлүүэх шаардлагатай байна.
- АТГ-аас санаачлан бусад хууль хяналтын байгууллагатай хамтран гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх, шийдвэрт ашиглах аргачлалыг боловсруулан, мөрдөж турших, үр нөлөөг сайруулах нь авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэхэд чухал үр нөлөөтэй байх болно.
- Эцэст нь судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан бусад төрийн байгууллага, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь үнэлэлт дүгнэлт өгдөг байх шаардлагатай байна.